

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын
сайдын 2013 оны 04 сарын 11-ны өдрийн
1/13 дугаар тушаалын хэрслэлт

ЦУСНЫ ХҮНДЭТ ДОНОРЫГ СУВИЛУУЛАХ ЖУРАМ

УХА0295

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Донорын тухай хуулийн 15.1-д заасан цусаа 35-аас дээш удаа өгсөн цусны донор хүн /цаашид “цусны хүндэт донор” гэх-/ийг жилд нэг удаа рашаан, сувилалд үнэ төлбөргүй сувилуулхтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Энэхүү журамд холбогдох шалгуур, нөхцөлийг хангасан Монгол Улсын иргэн, Монгол Улсад байнга оршин суудаг гадаадын иргэн хамрагдах эрхтэй.

1.3. Цусны хүндэт донор нь дотоодын магадлан итгэмжлэгдсэн рашаан сувилал болон нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай гэрээ хийсэн амралт, рашаан сувилалын аль нэгэнд жилд нэг удаа үнэ төлбөргүй амарч сувилуулах эрхтэй.

1.4. Цусны хүндэт донорын талаарх мэдээллийн нууцлалыг мэдээлэл авсан байгууллагууд Донорын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль, тогтоомжид заасны дагуу чандлан хадгална.

Хоёр. Рашаан, сувилалд сувилуулах хүсэлтийг хянан шийдвэрлэх

2.1. Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь 35-аас дээш удаа цусаа өгсөн цусны хүндэт донорын дэлгэрэнгүй мэдээллийг /Мэдээлэлд овог, нэр, регистрийн дугаар, гэрийн хаягийг багтаасан байна/ жил бурийн 7 дугаар сарын 01 болон 12 дугаар сарын 01-ний дотор жилд 2 удаа албан бичгээр болон цахим хэлбэрээр Нийгмийн хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.2. Нийгмийн хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэхүү журмын 2.1-д заасан мэдээллийг Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад албан бичгээр болон цахим хэлбэрээр хүргүүлж, мэдээллийн нэгдсэн санд оруулна.

2.3. Аймаг, дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага нь мэдээллийн нэгдсэн санд орсон цусны хүндэт донорын нэрсийн жагсаалт, регистрийн дугаарыг үндэслэн рашаан сувиллын эрхийн бичгийн үнийг 100 хувь, орон нутгийн нийтийн тээврийн тарифт үнээр унааны зардлын хамт олгоно.

2.4. Цусны хүндэт донор нь сум, хорооны нийгмийн ажилтанд рашаан сувиллын хөнгөлөлтөд хамрагдах хүсэлтээ гаргаждаа дараах баримт бичгийг бүрдүүлж өгнө:

2.4.1. иргэний үнэмлэх, хуулбарын хамт;

2.4.2. рашаан сувилалд амрах эрхийн бичгийн хуулбар;

2.4.4. нийслэлд амьдарч байгаа хүндэт донор иргэний хувьд Монголын донорын холбооны хүндэт донорын үнэмлэх, аймаг, суманд амьдарч байгаа хүндэт донор иргэний хувьд аймгийн Улаан загалмайн хорооны үнэмлэх тодорхойлолт;

2.4.5. орон нутгийн нийтийн тээврийн тарифт үнээр замын зардал төлсөн баримт эсхул нэхэмжлэл.

2.5. Энэхүү журмын 2.1-д заасан мэдээллийн бодит байдлыг Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцна. Мэдээллийн үнэн зөв эсэхэд донорын эрх ашгийг хамгаалах иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж болно.

2.6. Аймаг, дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага нь тухайн цусны хүндэт донор нь эрүүл мэндийн даатгалтай бол рашаан сувиллын хөнгөлөлтийг эрүүл мэндийн даатгалтай иргэний тарифаар, хэрэв цусны донор нь эрүүл мэндийн даатгалгүй бол даатгалгүй иргэний төлөх тарифаар тооцон олгоно.

2.7. Аймаг, дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага нь цусны хүндэт донорын сувиллын төлбөрийг рашаан сувилалын нэхэмжлэлийг үндэслэн тухайн байгууллагын дансанд, хэрэв иргэн сувилалд төлсөн төлбөрөө нөхөн авах бол тухайн иргэнд банкаар дамжуулан олгоно.

Гурав. Бусад

3.1. Энэхүү журмын хэрэгжилтэд нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний байгууллага хяналт тавина.

3.2. Энэхүү журамд заасан баримт бичгийг хуурамчаар үйлдсэн, худал мэдээлсэн, буруу тогтоосон байгууллага, албан тушаалтан, иргэнд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэж, илүү олгогдсон төлбөрийг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

3.3. Цусны донорын талаарх мэдээллийг хууль бусаар ашигласан тохиолдолд мэдээллийн нууцыг алдсан, түгээсэн байгууллага, албан тушаалтан хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээнэ.

Эрмүл мэнд спортын сайдын
2015 оны 05 сарын 19 дугаар тушаалын хавсралт

**ДОНОРТ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨНГӨЛӨЛТТЭЙ
ҮЗҮҮЛЭХ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГТ ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ХАМРУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Хүмүүнлэг, энэрэнгүй сэтгэлээр донорын үйлсэд идэвхитэй оролцсон донорт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх, эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулахтай холбогдох харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 Донорт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх, жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулахдаа Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, эдгээр хуулиудад нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг үндэслэнэ.

1.3 Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь хүний амь насыг аврахын төлөө сайн дураараа цус, эд, эрхтийн өгсөн донорын талаарх мэдээллийн санг бий болгож эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлтэй үзүүлэх, жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамрагдах доноруудын мэдээллийг харьяалах эрүүл мэндийн байгууллагад хүргэн хяналт тавьж ажиллана.

Хоёр. Донорт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх, эрүүл мэндийн үзлэгт хамруулах

2.1. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх, жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд үнэ төлбөргүй хамрагдах донорын дэлгэрэнгүй мэдээллийг албан бичгээр болон цахим хэлбэрээр тухайн донорын харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн газарт жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор хүргүүлнэ.

2.2. Аймаг, дүүргийн эрүүл мэндийн газар нь донорын мэдээллийг харьяа эрүүл мэндийн байгууллагад цаг тухайд нь хүргэнэ.

2.3. Донор нь дараах үзлэг, шинжилгээг дараалал харгалзахгүйгээр үнэ төлбөргүй хийлгэнэ.

Аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагад:

- Дотор
- Мэдрэл
- Нүд
- Чих, хамар хоолой
- Эмэгтэйчүүд
- Мэс засал
- Хэвлэлийн хөндийн хэт авиа
- Зүрхний цахилгаан бичлэг
- Тархины цахилгаан бичлэг
- Рентгэн шинжилгээ

Цусны алба:

- Резус сөрөг донор эмзгтэйчүүд жирэмсэн тохиолдолд резус Д-ийн эсрэг үүссэн эсрэг бие илрүүлэх, таньц тодорхойлох, кумбсын шинжилгээ,
- Доноруудын ийлдсэнд агуулагдах төмөр, ферритины хэмжээг тодорхойлох шинжилгээ.

2.4. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв нь дараах доноруудад "донор" болохыг нотолсон тодорхойлолт, баримт бичгийг олгоно.

2.4.1. Цус, сийвэнгээ 35-аас дээш удаа цусаа бэлэглэсэн мөн сүүлийн 2 жилд сайн дурын, авлагагүйгээр 8-12 удаа цус, эсвэл 16-20 удаа сийвэнгээ бэлэглэсэн,

2.4.2. Эд эрхтэнээс бэлэглэсэн амьд донор.

2.5. Аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллага нь төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн "донор" болохыг нотолсон тодорхойлолт, баримт бичгийг үндэслэн цус, сийвэнгийн доноорт жилд нэг удаа, эд, эрхтэний амьд донор болсноос хойш 2 жил дараалан жилд нэг удаа төр хариуцах тусlamж үйлчилгээнээс гадна энэ журмын 2.3-т заасан эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд үнэ төлбөргүй хамруулна.

Гурав. Бүрдүүлэх баримт бичиг

3.1. Энэ журмын дагуу эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд үнэ төлбөргүй хамрагдах донорууд дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

- 1) Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, цусны салбар төвүүдийн Донор болохыг нотолсон тодорхойлолт, баримт бичиг
- 2) Иргэний үнэмлэхний хуулбар
- 3) Цусны донор бол хүндэт донорын үнэмлэх.

Дөрөв. Бусад

4.1. Энэхүү журмын 2.4-д заасан мэдээллийн үнэн бодит байдлыг төв эмнэлэг, тусай мэргэжлийн төв хариуцаж, мэдээллийг зөв тодорхойлж, баримт бичиг олгосон эсэхэд аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар хяналт тавина.

4.2. Энэхүү журамд заасан "донор" болохыг нотолсон тодорхойлолт, баримт бичгийг хурамчаар үйлдсэн иргэн, эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний хөнгөлөлтөд хамрагдах донорыг буруу тоогосон, тодорхойлолтыг үндэслэлгүйгээр буюу хурамчаар үйлдсэн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага тооцно.

4.3. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв нь энэ журмын 2.1-д заасан донорын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, мэдээ, тайланг улирал, хагас, бүтэн жилээр гарган Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлнэ.